



**НЭГ. СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ:**

Сумын төсвийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр төсвийн орлого 117.1 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна.



СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар

Үзүүлэлт	2024 оны жилийн төлөвлөгөө	2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь
Нийт орлого	29,230.7	33,027.2	113.0
Татварын орлого	22,096.4	26,297.1	119.0
Татварын бус орлого	632.7	500.4	79.7
Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	3,037.3	2859.6	94.1
Эргэж төлөгдөх зээл	300.0	205.8	68.6
Урьд оны харилцах дансны үлдэгдлээс	3,164.3	3,164.3	100.0
Нийт зарлага	29,230.7	28,063.6	96.0
Урсгал зардал	7,008.5	6,803.8	97.1
Хөрөнгийн зардал	7,537.4	6,834.5	90.7
Эргэж төлөгдөх зээл	300.0	40.0	13.3
Төвлөрүүлэх орлого	14,384.8	14,384.8	100.0
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-		



**СУМЫН ОРЛОГО БА САНХҮҮЖИЛТИЙН
ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ:**

Сумын төсвийн нийт орлого 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 26,797.4 сая төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 17.9 хувь буюу 4,073.5 сая төгрөгөөр давж өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс татварын орлого 22,096.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 26,297.1 сая төгрөгт хүрч 4,200.7 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 627.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 500.4 сая төгрөгт хүрч 127.1 сая төгрөгөөр тасарч байна.

Санхүүжилтийн хувьд сумын нийт зардлын санхүүжилтийг 100 хувь олгосон.



СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар

Сумын 2024 оны татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл

Үзүүлэлт	Жилийн төлөвлөгөө	Өссөн дүнгээр		
		Хүлээгдэж буй гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Гүйцэтгэлийн хувь
Нийт орлого	22,723,904.3	26,797,443.9	4,073,539.6	117.9
1.Татварын орлого	22,096,404.3	26,297,065.6	4,200,661.3	119.0
1.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	15,340,400.8	17,197,559.5	1,857,158.7	112.1
1.2. Үйл ажиллагааны орлого	738,000.0	1,274,400.8	536,400.8	172.7
1.3. Хөрөнгийн орлого	1,200,000.0	1,354,216.1	154,216.1	112.9
1.4 Суутгагчийн татвар	1,586,325.2	2,744,424.8	1,158,099.6	173.0
1.1.1 Татварын буцаан олголт	(857,909.4)	(857,909.3)	0.1	100.0
1.5. Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,221,000.0	1,100,097.0	(120,903.0)	90.1
1.6.Галт зэвсгийн албан татвар	12,620.0	12,912.0	292.0	102.3
1.7. Малд ногдуулах албан татвар	28,757.7	51,958.2	23,200.5	180.7
1.8.Улсын тэмдэгтийн хураамж	450,000.0	1,119,044.5	669,044.5	248.7
1.9. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	30,000.0	15,906.1	(14,093.9)	53.0
1.10.Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,300,000.0	983,165.5	(316,834.5)	75.6
1.11. Газрын төлбөр	967,210.0	1,119,491.3	152,281.3	115.7
1.12 Газрын дуудлага худалдааны орлого	300,000.0	450,019.8	150,019.8	150.0
2. Татварын бус орлого	327,500.0	50,358.5	(277,141.5)	15.4
2.1 Торгуулийн орлого	22,723,904.3	26,797,443.9	4,073,539.6	117.9
2.2 Бусад орлого	22,096,404.3	26,297,065.6	4,200,661.3	119.0



Төсвийн орлогын тал дээр авч хэрэгжүүлсэн ажил:

Сумын 2024 оны төсвийн орлогыг нэр төрлөөр биелүүлэх арга хэмжээг оны эхнээс хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

1. Цагдаагийн газартай хамтран далд бууг илрүүлэх бууны татвараа төлөөгүй иргэдийн татварын төлүүлэх
2. Сумаас иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын газрын эзэмшлийн гэрээг дүгнүүлэх мэдэгдлийн хүргүүлж байгаа бөгөөд газар ашигласны төлбөр, хугацаа сунгуулаагүйг цаашид газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг дуусгавар болгон ажиллаж байна. Өндөр газрын төлбөртэй албан байгууллагуудын захирал, нягтлан бодогч нартай хамтарсан уулзалт хийж татварын өр төлбөрөө барагдуулах арга хэмжээ аван ажиллалаа.
3. Хүү торгуулийн орлогыг байгууллага бүрээр нь сар бүр гүйцэтгэл гаргаж төвлөрүүлэх арга хэмжээ авч
4. Цалин хөлсний орлогыг байгууллага тус бүрээр нь тулгаж өмнөх саруудын өр, авлагыг буруулах
5. Үйл ажиллагааны орлогыг тайланд хугацааны тайлангаар нь бүрэн төлүүлэх



СУМЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Сумын төсвийн нийт зарлагыг 29,230.7 сая төгрөг байхаар батлагдсанаас 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 28,063.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 96.0 хувьтай байна.


Мөн урсгал зардлыг 7,008.5 сая төгрөг байхаар батлагдсанаас 6,803.8 сая төгрөгийн зардал гарч 97.1 хувьтай байна.



СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар

Урсгал зардлыг байгууллагаар нь задалбал:






СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар

Урсгал зардлыг зарлагыг эдийн сангийн ангиллаар харуулбал:



- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал
- Хангамж, бараа материалын зардал
- Тоног төхөөрөмж, урсгал засварын зардал
- Томилолт, зочны зардал
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
- Ангилдаагүй бусад зардал
- Засаг даргын нөөцийн сан
- Хот тохижилтын зардал
- УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ




Нийт урсгал зардлын 2,103.7 сая төгрөг буюу 30.9 хувийг цалин хөлс болон нэмэгдэл цалин урамшил, 261.2 сая төгрөг буюу 3.8 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд, 1,405.7 сая төгрөг буюу 20.7 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 43.9 сая төгрөг буюу 0.6 хувийг хангамж, бараа материалын зардалд, 177.7 сая төгрөг буюу 2.6 хувийг тоног төхөөрөмж болон урсгал засварын зардалд, 3.7 сая төгрөг буюу 0.1 хувийг томилолтын зардалд, 27.0 сая төгрөг буюу 0.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд, 1,005.2 сая төгрөг буюу 14.8 хувийг ангилагдаагүй бусад зардалд, 120.9 сая төгрөг буюу 1.8 хувийг засаг даргын нөөцийн сангийн зардалд, 1,300.0 сая төгрөг буюу 19.1 хувийг хот тохижилтын зардалд, 354.8 сая төгрөг болон 5.2 хувийг урсгал шилжүүлэг болон тэтгэмж, намын суудал, төлөөлөгчдийн урамшууллын зардалд тус зарцуулаад байна.



СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар

Аймагт төвлөрүүлэх орлогыг 14,384.8 сая төгрөг байхаар баталсан нь сумын нийт зарлагын 49.8 хувийг эзэлж байна.





СУМЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2024 оны байдлаар 14,384.8 сая төгрөг байхаар батлагдсанаас 14,384.8 сая төгрөг төвлөрүүлж 100.0 хувьтай байна.

Сумын 2024 оны нийт зарлагын 25.6 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Сумын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон төсөл арга хэмжээгээр 2024 онд 7,398.3 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй шинээр хэрэгжүүлэх 79, он дамжуулан хэрэгжүүлэх 9 төсөл арга хэмжээ батлагдсан. 2024 оны хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 95.4 хувь, санхүүжилт 6,669.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, санхүүжилтийн гүйцэтгэл 90.1 хувьтай байна.



ХОЁР. СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сумын төсвийг батлахдаа орон нутгийн суурь болон нийт орлого, зарлагыг тооцсоны үндсэн дээр сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн сангаас суманд олгох санхүүжилтийг тооцдог.



Үүний дагуу сумын төсвийн суурь орлогыг 24,137.3 сая төгрөг, суурь зарлагыг 6,197.8 сая төгрөг хөрөнгө оруулалтын зардалд 854.5 сая төгрөг мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 17,084.9 сая төгрөг байхаар тооцож төсвийн үндсэн тэнцэл баталж, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг 3,740.5 сая төгрөг байхаар батлагдсан. Энэ нь 2024 оны төсвийн орлогоос 1,413.9 сая төгрөг буюу 6.2 хувиар нэмэгдүүлэн, төсвийн суурь зарлага 810.7 сая төгрөг буюу 11.6 хувиар бууруулан, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,700.1 сая төгрөг буюу 29.7 хувиар нэмэгдүүлэн баталсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 2024 оноос 703.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь сум орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сайн хөтөлж ирсэнтэй холбоотой урамшуулал нэмэгдсэнтэй холбоотой.



СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО


Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр ирэх онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

1. Татварын суурийг нэмэгдүүлэх, татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулах, татварын өнгөрсөн онуудын авлагыг бууруулах, татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх талаарх бодлогыг авч хэрэгжүүлнэ.
2. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогын нийлбэр дүнд шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах, тооцоолох ажлыг харьяа татварын албатай хамтран зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах
3. Хүү, торгуулийн орлогыг нэр төрөл бүрээр бүртгэн, гүйцэтгэлийг төвлөрүүлэгч байгууллага бүрээр гаргах
4. Татварын ерөнхий хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч татварын албанд татварын өртэй тохиолдолд улсын төсвийн санхүүжилтээс татварын өрд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэх



СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар



Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 27,695.1 сая төгрөг байхаар санал оруулж байна. Энэ нь Аймгийн Засаг даргын хянасан төсвийн орлогын хязгаарыг 3,557.9 сая төгрөг буюу 14.7 хувиар нэмэгдүүлэх санал оруулж татварын орлого 27,107.4 сая төгрөг, татварын бус орлого 587.7 сая төгрөг байхаар төлөвлөлөө.



Сумын 2025 оны төсвийн орлого:

Үзүүлэлт	2025 оны /Аймгийн хянасан/	2025 оны төвлөрүүлэх орлогын дүн	Зөрүү	Хувь
Нийт орлого	24,137,272.7	27,695,136.1	3,557,863.4	114.7
1.Татварын орлого	23,554,772.7	27,107,436.1	3,552,663.4	115.1
1.1 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	17,684,958.6	19,364,958.6	1,680,000.0	109.5
1.2 Үйл ажиллагааны орлого	1,097,000.0	1,097,000.0	-	100.0
1.3 Хөрөнгийн орлого	2,334,800.0	2,334,800.0	-	100.0
1.4 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 1,135,000.0	- 1,135,000.0	-	100.0
1.5 Үл хөдлөх хөрөнгийн татвар	280,885.5	1,280,885.5	1,000,000.0	456.0
1.6 Галт зэвсгийн албан татвар	12,040.0	12,040.0	-	100.0
1.7 Малд ногдуулах албан татвар		72,663.4	72,663.4	
1.8 Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	449,600.0	449,600.0	-	100.0
1.9 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20,000.0	20,000.0	-	100.0
1.10 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,500,000.0	1,500,000.0	-	100.0
1.11 Газрын төлбөр	1,135,488.6	1,135,488.6	-	100.0
1.13 Газрын дуудлага худалдаа	55,000.0	855,000.0	800,000.0	1,554.5
1.14 Шууд бус орлого	120,000.0	120,000.0	-	100.0
2. Татварын бус орлого	582,500.0	587,700.0	5,200.0	100.9
2.1 Торгуулийн орлого	255,000.0	255,000.0	-	100.0
2.2 Бусад орлого	327,500.0	327,500.0		100.0
2.3Төсөв байгууллагын өөрийн орлого		5,200.0	5,200.0	




СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГО

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь заалтын дагуу сумын төсвийн татвар орлогын орлогын 17 нэр төрлөөс 12 нэр төрлийн орлого нь суманд төвлөрч, нохойн албан татварыг сум тооцон иргэдээс төвлөрүүлдэггүй болно.



Төсвийн татварын орлого нь төсвийн нийт орлогын 97.9 хувь 27,107.4 сая төгрөг байхаар төлөвлөлөө. 2025 оны татварын орлого нь 12 нэр төрлийн орлогоос бүрдэнэ.



- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого
- Үйл ажиллагааны орлого
- Хөрөнгийн орлого /Хадгаламжын хүүгийн орлого/
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт
- Үл хөдлөх хөрөнгийн татвар
- Галт зэвсгийн албан татвар
- Малын тоо толгойн албан татвар
- Улсын тэмдэгтийн хураамж
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
- Хөг хаягдлын үйлчилгээний хураамж
- Газрын төлбөр
- Газрын дуудлага худалдаа
- СХХООС Татвар



**Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах
хөдөлмөр эрхлэлтийн орлого:**

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1-д заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар орлогыг 2022 оноос сумын төсөвт төвлөрүүлж байна. 2024 онд цалин хөлсний орлогын албан татвар төлдөг 640 аж, ахуй нэгж байгууллага, 1 иргэн татвар төлөгчөөр бүртгэгдсэн байна. Цалингийн сангийн өсөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн зэрэгт уялдуулан хувиар нэмэгдүүлэн 19,364.9 сая төгрөг хүрэхээр тооцсон ба 2024 оны батлагдсан орлогоос 4,024.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал оруулж байна.




Үйл ажиллагааны орлого:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.17-д заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8-д заасан орлогод ногдох албан татвар орлого нь сумын төсөвт төвлөрдөг. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.1 заасны дагуу татварын хувь хэмжээ 1 хувь болсонтой холбогдуулан татварын орлого болон татвар төлөгч иргэн 2023 онд 1501 байсан ба 2024 онд 20.7 хувиар нэмэгдэж 1812 иргэн татвар төлөгчөөр бүртгэгдсэн байна. Татварын хуульд өөрчлөлт орсноор иргэд татвар төлөгчөөр бүрдүүлэх таатай нөхцөл бүрдсэн байна. Үйл ажиллагааны орлогыг сүүлийн жилүүдийн гүйцэтгэл:



Үйл ажиллагааны орлого



	2021 он	2022 он	2023 он	2024 он
■ Төвлөрүүлсэн орлого	538,570.3	509,500.0	717,239.3	1,274,400.8
■ Татвар төлөгч	1,224	1,320	1,500	1,812

■ Төвлөрүүлсэн орлого ■ Татвар төлөгч

Иймд 2025 оны үйл ажиллагааны орлогыг 1,097.0 сая төгрөг байхаар тооцсон болно.



2025 оны хувьд 2,334.8 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь иргэд олгох хувьцааны ноогдол ашгийн суутгалын тооцсон болно.



Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.16-д заасны дагуу үйл хөдлөх хөрөнгийн орлого нь 2022 оноос 100 хувь суманд төсөвт төвлөрүүлж байна. Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөгчөөр 2024 онд 169.0 аж, ахуй нэгж байгууллага, 217 иргэн татварын цахим системд бүртгэгдсэн болно. Иймд 2024 онд 1,280.9 сая төгрөг байхаар төлөвлөж 2024 оноос 59.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн санал оруулж байна. Мөн урьд оны авлагыг бууруулж төсвийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр аймгийн татварын хэлтэстэй хамтран ажиллана.



Галт зэвсгийн албан татвар:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.2-д заасны дагуу галт зэвсгийн татвар нь сумын төсөвт төвлөрдөг. Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар албан татварын хувь хэмжээг тодорхой заасан байдаг.

Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар галт зэвсэг эзэмшигчид жил бүр доор дурдсан хэмжээний албан татвар ногдуулна:

№	Галт зэвсгийн төрөл	Албан татварын хэмжээ /төгрөгөөр/
1	Үзмэр, цуглуулга, спорт-сургалтын зориулалттай галт зэвсэг	15 000
2	Ан агнуур, харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг - 6,4 мм хүртэлх калибрын бүх төрлийн галт зэвсэг - 6,5 түүнээс дээш мм-ийн калибрын бүх төрлийн галт зэвсэг - үрлэн сумтай галт зэвсэг	30 000 60 000 30 000



2024 оны хувьд галт зэвсгийн татвар төлөгч 2023 оноос 38 буурсан ба 0.9 сая бууруулах санал байна.



Малын тоо толгойн албан татвар:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15-д заасны дагуу 2022 оноос эхлэн малын тоо толгойн албан татварыг сумын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Сүүлийн 5-н жилийн малын тоо:

Багийн нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1 дүгээр баг	21,331	16,032	19,537	24,347	21,202
2 дугаар баг	23,606	20,490	20,886	28,296	23,439
3 дугаар баг	7,930	6,327	6,119	7,064	5,962
4 дүгээр баг	22,811	19,938	20,813	23,827	22,925
5 дугаар баг	11,323	10,717	10,114	11,410	10,589
6 дугаар баг	19,012	15,306	12,407	12,764	10,470
7 дугаар баг	10,845	10,934	12,869	10,141	11,366
8 дугаар баг	9,893	9,408	8,478	11,035	11,892
9 дүгээр баг	22,252	14,617	15,822	19,041	16,747
10 дугаар баг	15,529	13,512	12,897	15,358	10,469
11 дүгээр баг	11,515	8,901	7,618	8,973	8663
Нийт дүн	176,047	146,182	147,560	172,256	153,724



2024 оны малын урьдчилсан тоогоор 32 буюу 49,531 толгой малаар буурсан байна. Үүнээс адуу 1157 буюу 4 хувиар, үхэр 7971 буюу 28 хувиар, тэмээ 53 буюу 19 хувиар, хонь 25779 буюу 40 хувиар, 15021 буюу 41 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Улсын тэмдэгтийн хураамж:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.3-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийн орлого нь сумын төсөвт төвлөрдөг. Төсвийн тухай хуулийн **23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж** -ийн орлого нь сумын төсөвт төвлөрнө гэж заасан байдаг. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.9 нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж гэж заасан байдаг. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг сүүлийн 5-н жилээр харуулбал:



СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар





Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг Аймгийн төсвөөс ирүүлсэн хязгаарын дагуу 449.6 сая төгрөг байхаар санал оруулж байна.



Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.8-д заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрын орлого нь сумын төсөвт төвлөрдөг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын **бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож** түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө. 33.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь **олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан** бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байна гэж заасан байдаг. Сумын хэмжээнд түгээмэлт тархацтай ашигт малтмал олборлодог 4 аж ахуй нэгж байгууллага байна. 2025 онд төвлөрөх түгээмэл тархайцтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 20.0 сая төгрөгөөр бууруулан байхаар санал оруулж байна.



Хог хаягдлын үйлчилгээний хураамж:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12-д заасны дагуу хог хаягдлын хураамж нь 2014 оноос эхлэн сумын төсөвт төвлөрч эхэлсэн.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 14/01 дугаар бүхий хурлын тогтоолоор хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийн хэмжээг тогтоож өгсөн. Уг тогтоолд:



СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

Хэрлэн сумын Засаг даргын
Тамгын газар


Хүн амын судалгааг сумын хэмжээнд жилийн эцсийн дүнгээр харуулбал:

Багийн нэр	2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Нийт өрх	Хүн ам	Нийт өрх	Хүн ам	Нийт өрх	Хүн ам	Нийт өрх	Хүн ам
1 дүгээр баг	1430	5770	1484	5801	1521	5904	1560	6071
2 дугаар баг	1593	5978	1622	5947	1593	5844	1597	5711
3 дугаар баг	581	2406	601	2446	608	2402	621	2373
4 дүгээр баг	1879	7126	1923	7189	1902	7161	1918	7002
5 дугаар баг	308	945	301	913	283	876	276	837
6 дугаар баг	1452	5019	1444	5119	1439	5120	1521	5233
7 дугаар баг	1266	4222	1314	4384	1357	4505	1397	4534
8 дугаар баг	579	1812	588	1777	569	1703	564	1690
9 дүгээр баг	1435	5294	1445	5316	1476	5395	1577	5536
10 дугаар баг	1347	4942	1351	4925	1327	4867	1244	4772
11 дүгээр баг	900	3169	961	3336	1020	3493	1127	3759
Нийт дүн	12770	46693	13034	47153	13095	47270	13402	47518



Хог хаягдлын хураамжийн орлогын гүйцэтгэлийг сүүлийн таван жилээр харуулбал:

Хог хаягдлын хураамжийн орлого





Хог хаягдлын хураамжийг орлогыг нэмэгдүүлэн 1,500.0 сая төгрөг байхаар тооцлоо.

Сумын 2025 оны хог хаягдлын хураамжийн орлого

д/д	Өрх, аж ахуй нэгж	Тоо	Төлбөр хураамж	Нийт	Суутгал	Төвлөрүүлэх орлогын дүн
1	Гэр хорооллын хүн амын тоо	26,266.0	2,500.0	65,665.0		787,980.0
2	Орон сууцны хүн амын тоо	21,252.0	2,500.0	53,130.0	10,626.0	510,048.0
3	Аж ахуй нэгж байгууллага	552	57,100.0	31,519.2		378,230.4
Орлогын дүн				150,314.2	10,626.0	1,676,258.4



Газрын төлбөр:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.14-д заасны дагуу газрын төлбөрийн орлого нь 2020 оноос газрын төлбөрийн орлогын 40 хувь нь суманд, 2022 оноос 100 хувь сумын төсөвт төвлөрдөг болсон. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 он 06 дугаар сарын 24-ны өдрийн 10/01 тоот тогтоолоор газрын төлбөрийн хил зааг, итгэлцүүрийн хувь, төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын нэр	2021 он		2022 он		2023 он		2024 он	
	Тоо	Төлсөн татвар	Тоо	Төлсөн татвар	Тоо	Төлсөн татвар	Тоо	ХБГ
Аж ахуй нэгж	128	106,046.4	157	400,361.0	105	608,510.8	128	1,048,329.8
Иргэн	550	10,864.4	484	30,560.9	725	25,671.0	653	48,463.1
Нийт дүн		116,910.8		430,921.9		634,181.8		1,096,792.9



Улсын хэмжээнд олгогдсон газрын эрхийг бүрэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэн, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахим хэлбэрт шилжүүлэх замаар газрын төлбөрийг бүрэн хураах цогц бодлогын арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлэх, мөн урьд оны татварын авлагыг бууруулах талаарх арга хэмжээг сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллана.



ТАТВАРЫН БУС ОРЛОГО

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д заасны дагуу сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.9.2. орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

23.9.3 хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого гэж заасан байдаг. Татварын бус орлого нь 3 нэр төрлийн орлогоос бүрддэгээс 2 нэр төрлийн орлого нь сумын төсөвт төвлөрдөг. Уг 2 нэр төрлийн орлого нь сумын төсөвт 632.7 сая төгрөг төвлөрүүлэхээр тооцлоо. Татварын бус орлого нь тодорхойгүй орлого болно.



Хүү торгуулийн орлого:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.2-д заасны дагуу хүү торгуулийн орлого нь сумын төсөвт төвлөрдөг. Цагдаагийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг газруудаас уг орлогын төвлөрүүлэхээр тооцлоо. Хүү торгуулийн 255.0 орлогыг сая төгрөг төвлөрүүлнэ.

Бусад орлого:

Бусад орлогыг 2025 онд 327.5 сая төгрөг байхаар аймгийн төсвөөс хязгаарыг баталсан дүнгээр нь тооцлоо.



Сумын 2025 онд баримтлах урсгал зардлын зарчим:

1. Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд **“ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ”**-ийг мөрдөж, хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллана.



2. Төрийн албан хаагчийн цалин хөлс:

Төрийн захиргааны албан хаагчийн цалингийн шатлал: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагчдын цалинг 6 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон. Засгийн газрын тогтоол батлагдсаны дараа уг нэмэгдлийг олгоно.

3. Төрийн захиргааны албан хаагчдад олгох тэтгэмж: Төрийн албаны тухай хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр орсон өөрчлөлтөөр суманд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор заасны дагуу 2025 онд 3 төрийн захиргааны албан хаагчдад уг мөнгөн урамшуулал олгогдоно;



СУМЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

Төсвийн нийт урсгал зардал 2025 онд 7,834.7 сая төгрөг байхаар төвлөвлөлөө.

Иймд 2025 оны төсөвт төрийн албан хаагчдын цалин хөлстөй холбоотой зардлыг бууруулахгүй төсөвт байгууллагуудын хэмнэх боломжтой үйл ажиллагааны зардлыг бууруулахаар тооцож намын суудал болон төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардал болон зарим тоног төхөөрөмж бараа материалын зардлыг нэмж тусгалаа.


Хот тохижилтын зардлыг хог хаягдлын үйлчилгээний хураамжтай уялдуулан 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 2,300.0 сая төгрөг байхаар тооцлоо.



УРСГАЛ ЗАРДАЛ

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар

Урсгал зардал





Урсгал зардлын 7.8 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын урсгал зардалд, 33.3 хувийг Засаг даргын тамгын газрын болон багийн ажлын албаны урсгал зардалд, 2.0 хувийг орон нутгийн нөөц хөрөнгийн зардалд, 29.4 хувийг хот тохижилтын урсгал зардалд, 27.5 хувийг боловсролын байгууллагуудын төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээний болон ашиглалтын зардалд тус тус зарцуулахаар төлөвлөлөө.




Төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд 2024 оноос 10 ажлыг шилжүүлж, шинээр 52 хөрөнгө оруулалтын ажил 9,373.3 сая төгрөг зарцуулахаар санал оруулж байна. 2025 онд орон төсвийн хөрөнгөөр 40 нэр төрлийн 1,623.7 сая төгрөгөөр хөрөнгө бус төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр санал оруулж байна.



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН сан

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 35.9 хувийг барилга, байгууламж, 27.5 хувийг их засвар, гэрэлтүүлэг, 34.8 хувийг тоног төхөөрөмж, 1.8 хувийг зураг, төсвийн зардал зарцуулахаар санал оруулж байна.





ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

2025 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил, төсөл хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулахад дор дурдсан чиглэл баримтлах. Үүнд:

Тус сангийн хөрөнгийг сумын ОНХС-д хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 60 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн “Журам батлах тухай” 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлах;

Сумын ОНХС-д хуваарилах шилжүүлгийг тооцохдоо Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу хуваарилагдах суурь дүнг 50 хувь байхаар тооцох;

Иргэдийн ирсэн саналыг иргэдийн нийтийн хурлаар эрэмбэлсэн ажлуудыг санал оруулж байна.




ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.км ²	Хүн амын тоо /мян.хүн/	Аймаг хүртэлх зай /км/	Ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбай	Ашигт малтмал болон газрын тосны индекс	Итгэлцүүрийн хуваарилалт				Урамшуулал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Сумдын ОНХС-д хуваарилах суурь дүн	хандив	нийт дүн
						Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Ашигт малтмал, газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Итгэлцүүр нийт дүн						
Хэрлэн сум	0.281	47.3	0	437.3	0	2,955,176.2	12,387.4	13,573.5	2,981,137.0	747,732.3	-	2,650.0	3,731,519.3	9,000.0	3,740,519.3



Орон нутгийн хөгжлийн сангийн урамшуулал:



Орон нутгийн хөгжлийн сангийн урамшуулал нь 2023 оноос 49.4 хувь 377.6 сая төгрөгөөр, 2024 оноос 41.7 хувь 220.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн урамшууллыг 2013 оноос тогтмол авч хэвшсэн.